



Шантралгүй тэмцээр л

Хятадад мянга мянган хүн албадан
нүүлгэлтэнд өртсөөр – Товчлол

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



“Би амьдралынхаа төлөө эцсээ хүртэл тэмцэнэ”.

Ү Ли Хун 2011 оны 1 дүгээр сард Бээжингийн Шиаохонмен суурин дахь гэрүүдийг албадан нураах үед ирж гэрээ нураалгалгүй авч үлдсэн юм.



Зохих хуулийн баталгаа, хамгаалалтгүйгээр хүмүүсийг гэр орон, фермийг нь албадан нүүлгэх явдал Хятадад хэвийн үзэгдэл болсон нь хүний эрхийн ноцтой зөрчлийн илрэл билээ. Гэнэт, хүч хэтрүүлэн хэрэглэн албадан нүүлгэх явцад нилээдгүй хүн амь насаа алдсан байна. Албадан нүүлгэх ажиллагаа ихэвчлэн айлган сүрдүүлэх, зодох, хүн хулгайлах, амьдаар нь булах зэрэг халдлагаар эхэлдэг аж. Албадан нүүлгэлтэд өртсөн оршин суугчдад багахан хэмжээний эсвэл ямар ч нөхөн төлбөр өгдөггүй бөгөөд ядаж өөр байр, газраар ч хангадаггүй байна.

Заримдаа орон нутгийн эрх баригчид болоод хувийн хэвшил, газрын бизнес эрхлэгчдийн хоорондох газрын нууц наймааны хохирогчид нь оршин суугчид болдог.

Бээжингийн Шиаохонмень суурингийн иргэд эдгээр халдлагын хэв маягийг сайн мэднэ. 2011 оны 1 дүгээр сарын 13-нд Бээжингийн Чаояань дүүргийн нэгэн сууринд ямар ч дугааргүй машинууд ирж, дотроос нь бараг зуу гаруй хүн бууж, нураахаар төлөвлөгдсөн газар дээр ирсэн байна. Хэдийгээр тэд хэн гэдгээ хэлээгүй ч орон нутгийн цагдаа, “ченгуань” (хотын менежмент) болон хотын захиргааны хууль сахиулдаг Хятадын хагас цэрэгжсэн цагдаа нар байсан хэмээн гэрчүүд өгүүлсэн юм.

Ногоон бүс байгуулахын тулд төрөөс хувийн газрыг нь хурааж авах мэдэгдлийг зарим оршин суугч (10,000 гаруй өрх) 2006 онд хүлээн авчээ. Хэдэн сарын дараа өрх бүр шинэ байр авах дарааллыг тайлбарласан товхимол хүлээн авсан байна. Хожим нь тэд суурингийн

захиргаа тосгоны зөвлөлийн гишүүдтэй сүлбэлдэж 2005 онд үл хөдлөх хөрөнгийн компанитай нууцаар тохиролцсоныг, улмаар тэдэнд санал болгосон байр нь Бээжингийн төвөөс 4-5 км зайд, сургууль, эмнэлэг нийтийн тээврийн хэрэгслээс алслагдмал байрлалтайг мэджээ. Өөрөөр хэлбэл олон улсын хуулинд заасан хангалттай мэдээлэл, зөвшилцөл байгаагүй гэсэн үг.

Олон хүн албадан нүүлгэх гэрээнд гарын үсэг зурахаасаа татгалзсанахаа төлөө элдэв халдлагад өртөж байна. Тэднийг үл таних машин дагаж, цагдаагийн газарт саатуулан, гэр оронд нь халдаж, оршин суугчдын зөвшилцөлд хүрэх гэсэн оролдлогуудыг нухчин дардаг ажээ. Ихэнх нь эцэстээ бууж өгч, өөр газар руу явжээ. Гэхдээ Ү Ли Хун бууж өгөлгүй үлдсэн юм.



2012 оны 1 дүгээр сард ганцхан Ү Ли Хунгийн байшин хуучин тосгонд торойн үлдсэн байв. Тэрээр дуу чимээ ихтэй барилгын бүст 14 настай хүү, нөхөр, хадам аавтайгаа амьдарч байлаа. “Эрх баригчид байнга дарамталж, заримдаа гэр рүү нь асар хурц гэрэл өдөр шөнөгүй тусгадагаас би шөнө унтаж чаддаггүй бас их айдаг. Хүү маань сайн амарч чадахгүй байсан болохоор сурлага нь муудсан” хэмээн Ү Ли Хун хэлсэн билээ.

Ү Ли Хун албадан нүүлгэлттэй үргэлжлүүлэн тэмцсээр байсан бөгөөд “Энэ бол шударга бус явдал. Би амьдралынхаа төлөө эцсээ хүртэл тэмцэнэ” хэмээн өгүүлсэн юм. Тэрээр гэр бүлийнхнийхээ аюулгүй байдлыг бодон 2011 оны 2 дугаар сард тэмцлээ зогсоожээ.

Гэр орноо алдсан олон иргэн

Шиаохунмень суурингийн оршин суугчидтай адилхан нөхцөл байдалтай тулгарчээ. Тэд ажил, сургууль, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ, нийтийн тээврээс хол чанар муутай байранд амьдрахаас өөр аргагүйд хүрсэн байна.

Тариачид амьдралынх нь ганц баталгаа болсон газраа алдсаныхаа дараа ядуурах нь түгээмэл байдаг. Шударга ёсыг эрсэн зарим нэг нь тэмцлийн хэт хурц хэлбэрийг сонгон, дуу хоолойгоо хүргэхээр өөрсдийгөө галдан шатаасан явдал ч гарах болжээ.

Шантралгүй тэмцсээр л: Хятадад мянга мянган хүн албадан нүүлгэлттэй тулгарч байна (Индекс: ASA 17/011/2012) тайлангийн судалгаа хийх 2 жил гаруйн хугацаанд Эмнести Интернэшнл олон улсын болон Хятадын хуульч, хүний эрхийн

Жилийн турш Цунчингийн “хоолны гудамж” дах нэгэн гэр бүл 6 давхар их дэлгүүрийн барилгын ажилд орон байраа чөлөөлж өгөхөөс татгалзсан юм. Барилгынхан тэдний ус, гэрэл цахилгааныг тасалж, гурван үеэрээ амьдарсан гэрийг нь тойруулан 10 м гүн нүх ужжээ. Байрны эзэд барилгын талбай руу нэвтэрч, байшингийнхаа дээр Хятадын тугийг мандуулсан байна. Эцэст нь тэд 2007 онд үл хөдлөхийн компанитай зөвшилцөлд хүрчээ.

идэвхтэн, эрдэмтэд ярилцаж, 2009 оны 1 дүгээр сараас 2012 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд албадан нүүлгэсэн 40 гаруй тохиолдлыг судалсан юм. Хятад дах албадан нүүлгэх ажиллагааг тойрсон нөхцөл, хүч хэрэглэхэд хүргэж буй хүчин зүйлсийг судлахаар ажиллаж олон улсын хэм хэмжээг зөрчсөн засгийн газар, харьяа агентлагийн ажлын хэв маягийг тодорхойлохыг чармайлаа.



2008 оны Олимпийн тоглолтонд зориулан Бээжинд тохижилтын ажил өрнөж байгаа нь. Хэдэн үеэрээ хотын төвд амьдарсан оршин суугчдыг хүчээр хотын зах руу шилжүүлсэн юм. 2006 оны 11 сар

ОРШИЛ

Албадан нүүлгэлт нь Хятадад олныг хамарсан хамгийн томоохон дургүйцэл, бухимдлын эх үүсвэр болж нийгэм, улс төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

1949 онд коммунист хувьсгал буюу Мао Зедунаар удирдуулсан Хятадын Коммунист Намын тариачдад газар эзэмшүүлэх, томоохон дайчилгааны бодлогууд нь орон нутгийн элитүүдийн эдийн засаг, нийгмийн хяналтыг устгасан юм. Нам газрын эздээс газрыг нь хүч хэрэглэн булаан авч тариачдад тарааж байв.

1950-аад оны сүүл гэхэд газрыг хамтралжуулахаар орон нутгийн бүх газрыг газар тариалангийн нэгдлийн мэдэлд өгчээ. 1976 онд Мао Зедун нас барсны дараахан Хятадын эдийн засгийн хөгжлийг дэмжихээр эрх зүй, зах зээлийн шинэчлэлийг дэмжсэн

шинэтгэлийн бодлогыг Дэн Сяопинг хэрэгжүүлсэн юм. Хууль ёсны эрхийн тухай ойлголт, зах зээлийг сэргээсэн нь Хятад дах газар эзэмших болон орон байрны бодлогод бодит нөлөө үзүүлэх ёстой байв.

1982 оны Үндсэн хуулиар анх удаа Хотын газрыг төр, хөдөө болон хотын захын газрыг "нэгдэл" эзэмшинэ гэж тунхагласан юм. "Нэгдэл" хэмээх энэ үгийг тодорхой тайлбарлаж заагаагүй ч хөдөө орон нутагт одоо явагдаж байгаа албадан нүүлгэлттэй холбоотой хямралын гол гогцоо болдог.

Голдуу тосгоны зөвлөл " нэгдэл"-ийг хянадаг. Гэвч 1982 оны дараахан олгосон концессийн эрх өнөөг хүртэл байсаар. Хүмүүс газрыг ашиглах эрхтэй, өөрөөр хэлбэл газрыг өмчилдөггүй ч тодорхой хугацаагаар хөдөө орон нутагт 30 жил, хотуудад 70



хүртэл жил ашиглах эрхтэй ажээ.

Хотод газар ашиглах эрхийг баталсан явдал нь хувийн гэсэн тодотголтой газрын зах зээл үүсэх нөхцлийг бүрдүүлж өгсөн юм. 1990-ээд онд төрийн байгууллагууд ажилчдынхаа байруудыг хувьчилж, оршин суугчдад нь бага хэмжээний үнээр зарж байжээ. Үл хөдлөх хөрөнгийн худалдаа ингэж идэвхжиж эхэлсэн юм.

Угаас орон байрны хомсдолтой Хятад улсад үл хөдлөх хөрөнгийн үнэ тэнгэрт хадаж эхэлжээ. Барилгынхан зам болон бусад хотын захиргааны төслийг үнэ төлбөргүй барьж өгөх зэргээр орон нутгийн эрх баригчдыг лоббидож газар ашиглах эрх худалдаж авдаг байжээ.

Албаны хүмүүс ч хөгжлийг бүхний тэргүүнд тавьж хамтран ажилладаг байна. Энэ нь авилга, хээл хахуулийг

байнга дагуулдаг нь нууц биш.

Судалгаанаас харахад зөвхөн 1991-2003 оны хооронд Бээжин хотод л гэхэд хагас сая өрх гэр орноо алджээ. Орон нутагт гэхэд эрх баригчид 1990-2010 оны хооронд 16,5 сая га газрыг хураан авсан байна. Нөхөн төлбөрийн асуудал төрийн хууль тогтоомжид тусгагдсанаас хамаагүй буурсан байна.

Албадан нүүлгэлттэй холбоотой асуудал 2008 оны Бээжингийн Олимпийн бэлтгэл үеэс л олон улсын анхааралд орсон юм. Бээжингийн Олимпийн тоглолтонд бэлдэх үед хэдэн зуун өрхийг хүчээр нүүлгэснийг Хятад болон олон улсын хүний эрхийн идэвхтнүүд бүртгэн авчээ.

Хэдийгээр олон хүн Олимп эхлэхээс өмнө олон улсын анхаарлыг татсанаар энэ бүх хүчирхийллийг

бууруулж чадна гэж найдаж байсан ч харин ч улам нэмэгдсэн юм.

1990-ээд онд төрийн байгууллагууд ажилчдынхаа байруудыг хувьчилж, суугчдад нь бага хэмжээний үнээр зарж байв.



Бээжингийн Дунчэнцү Бейжонбү Хутун Цэцэрлэг № 3 –ын нуранги. 1931-1937 оны хооронд энэ байшинд Хятадын алдарт архитекторч Лиан Сичен, Линь Хуй-инь нар амьдарч байжээ. Уг байшинг Үндэсний өвийн тухай хуулиар хамгаалсан боловч гэрээлэгч нь 2012 оны 1 дүгээр сард “засвар” хийх зорилгоор нурааж олны дургүйцлийг хүргэжээ.

АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

Олимпоос хойш гэр орон, тариан талбайгаасаа хөөгдөн гарсан хүний тоо тодорхойгүй ч, одоо өссөн нь гарцаагүй. 2011 оны Ландеса Орон Нутгийн Хөгжлийн Институтийн хийсэн судалгаагаар 1990-ээд оноос хойш хөдөө, тосгон суурингийн газрын 43.1 хувийг хураан авсан бөгөөд энэ тоо 2007 оноос хойш тогтмол нэмэгдэж иржээ.

Албадан нүүлгэх ажиллаагаа маш хурдацтай явагдаж байгаа нь орон нутгийн албаныхан, үл хөдлөх хөрөнгийн компаниудын ашиг сонирхол нэгдсэний тод илрэл юм. Хятадын Коммунист нам ямар ч хамаагүй аргаар эдийн засгийн өсөлтийг хангасан хүмүүсийг албан тушаалд дэвшүүлдэг. Газрыг өөрчлөн шинэ зам, үйлдвэр эсвэл орон сууцны цогцолбор барих нь хамгийн

нүдэнд харагдахуйц үр дүнтэй аргад тооцогдож байна.

Хөгжлийн төлөө газрыг чөлөөлөх нь орон нутгийн эрх баригчдад санхүүгийн урамшуулал олдох ашигтай. Бусад орлогоос ялгаатай нь газар худалдаалсан орлого тухайн орон нутгийн санд үлддэг. 1990-ээд оны дунд үед татварын бодлогыг шинэчилснээс хойш тогтолцоогоороо төсвийн гачигдалд ороод байсан орон нутгийн засаг захиргааны хувьд газар түрээслэх нь орлогын хамгийн том эх үүсвэр болжээ. Дэлхийн эдийн засгийн уналтын улмаас орон нутгийн захиргаа төслүүдээ санхүүжүүлэхийн тулд төрийн банкуудаас зээл авч, газар зарсан мөнгөөрөө хүү, зээлээ төлж байгаа тул газрын худалдаа улам дордоод байна. 2009 онд газар зарж олсон хөрөнгө нь тухайн орон нутгийн төсвийн бараг хагасыг буюу 40-өөс дээш хувийг бүрдүүлжээ. 2010



онд улсын хамгийн том 4 хотод газар зарсанаас олсон орлого нь өмнөх оныхтой харьцуулахад 70 хувиар есчээ.

Газрын төлөө оршин суугчдыг гэр орноос нь хөөн гаргахад засаг захиргаа, үл хөдлөх хөрөнгийн компаниудын ашиг сонирхол давхацсан үед хүч хэрэглэх тохиолдол асар их. Зарим тохиолдолд хотын захиргааныхан өөрсдийн компанийг байгуулж, ашиг сонирхлын зөрчилдөөн үүсгэснээр хүчирхийлэл гарах үндсийг тавьж байна.

Хятадын улс төрийн тогтолцооноос хамааран олон нийтийн хяналт хязгаарлагдмал нөхцөлд засаг захиргааныхан ажилладаг.

Албаныхан хувийн хэвшлээс авлига авсан олон хэргийг мэдээллийн хэрэгслүүд баримтжуулжээ. Албадан нүүлгэхтэй нүүр тулсан иргэд Хятад

улсын хуулийн дагуу хамгаалалт тун бага эдэлдэг бөгөөд эрхээ эдлэхийн тулд асар их саад бэрхшээлтэй тулгардаг.

Зураг: 2012 оны 7 дугаар сарын 4-нд Бээжингийн өмнөд хэсгийн Шилиүзуанг тосгоныг нураах үеэр. Бульдозертэй аюулгүйн албаныхан үүрээр гэнэт хүрч ирж хэдхэн цагийн дотор тосгоныг нураажээ.

“Ямарваа хуулийн хамгаалалт, найдах зүйлгүй учраас тосгоныхон албадан нүүлгэх, өөр газар дахин суурьшихыг хүсэхгүй байх нь аргагүй шүү дээ. Өнөөг хүртэл би энэ хөгжүүлэгчидтэй уулзаагүй, гэрчилгээ энэ тэрийг нь ч харж байгаагүй.”

2010 онд ямар ч анхааруулга, тайлбар, зөвшилцөлгүйгээр Шандун мужийн Вейфан хотын Вейсанли тосгоныг нураасны дараа Ванг Жинвен Вейфан хотын захирагчид ийнхүү нээлттэй захидал бичжээ.

Албаныхан бизнесийн байгууллагуудтай хуйвалдан эдийн засгийн хөгжлийн нэрийг барьж газар булааж, газрыг барьцаалан тосгоны иргэдийн ашиг сонирхлыг хохироож байна.

Линь Зүлиань, Гуандун мужийн Ү Кань тосгоны шинээр сонгогдсон тэргүүлэгч,

2012 оны 3 дугаар сарын 19



ГУАНДУН МУЖИЙН Ү КАНЬ ТОСГОН

Хятадын зүүн хэсгийн Гуандун мужийн Ү кань тосгон 2011 онд дэлхий нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татаж чадсан юм.

Тосгоны иргэд хэдэн сарын турш газрыг нь нууцаар зарах гэсэн оролдлого, авилгалын эсрэг тэмцжээ. Орон нутгийн коммунист нам газар зарахдаа иргэдтэй огт зөвшилцөөгүй, зөвхөн барилгын ажил эхэлсний дараа л энэ талаар олж мэдсэнээ тосгоныхон хэвлэлээр өгсөн ярилцлагууддаа хэлж байв. Газрыг нь засаг захиргааныхан хулгайлах явдалтай сүүлийн 40 жилийн турш тэмцэж ирснээ ч оршин суугчид мөн өгүүлж байв.

9 дүгээр сард тосгоныхон жагсаж, захиргааны байр руу дайран орсон байна. 12 дугаар сард мянга гаруй цагдаа тосгонд ирж 9 сарын

жагсаалыг зохион байгуулсан гэж 5 хүнийг барьжээ. Баривчлагдсан хүмүүсийн нэг нь Шү Жиньбо байсан бөгөөд баривчлагдсанахаа дараах 3 дахь өдөр нас баржээ. Гэр бүлийнхэн болон тосгоныхон түүнийг эрүү шүүлтэнд өртсөн байж болзошгүй тухай сэтгүүлчдэд мэдэгдсэн бөгөөд нүүрэнд нь хөхөрсөн, зүсэгдсэн газар нилээд байжээ.

Шү Жиньбог нас барсны дараа хилэгнэсэн оршин суугчид тосгоныхоо Коммунист намын тэргүүлэгчдийг хөөн гаргажээ. Тайван бус байдлыг намжаахын тулд мужийн удирдлага асуудалд оролцож, Ү кань тосгонд шинэ сонгууль явуулна гэдгээ амласан байна. 3 дугаар сард тосгоныхон сонгууль явуулж, сонгогдсон 2 тэргүүлэгч нь хоёулаа газрын төлөө тэмцлийг тэргүүлэхэд туслалцсан хүмүүс байв. Гэсэн хэдий ч Шү Жиньбогийн үхэлд

ямар ч бие даасан хараат бус мөрдлөг явуулаагүй, тосгоныхон одоо хүртэл газраа эргүүлэн авч чадаагүй байна.

ЗӨВШИЛЦӨЛ, АНХААРУУЛГА ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Энэ тайланд холбогдох мэдээллийг цуглуулах үед олон улсын хэм хэмжээгээр шаардсан албадан нүүлгэхээс өмнө зөвшилцөх, анхааруулга өгөх зарчмыг мөрддөггүй нь харагдсан билээ.

Нүүлгэн шилжүүлэх тухай хэн нэгний амнаас эсвэл нүүлгэн шилжүүлэхээс хэдхэн хоногийн өмнө хананд наасан мэдэгдлээс л олж мэддэг тухай оршин суугчид Эмнести Интернэшнлд дахин дахин нотолж байсан юм.

Мөн орон нутгийн эрх баригчид нээлттэй сонгогч явуулахгүй орхигдуулж байгаа тухай мэдээ Эмнести Интернэшнлд иржээ.



Оршин суугчид болон тэдний эмгөөлөгчид зарлагдсан хэдхэн тооны сонгол нь ердөө л үзүүлэн тоглолт төдий байсан тухай хэлж байсан юм. Орон нутгийн албаныхан заримдаа оршин суугчдад тэднийг нүүлгэх тухай мэдэгддэг бөгөөд ямарваа нэг татгалзсан хариу эсвэл өөр саналыг огт хүлээн авдаггүй, уулзалтын үеэр оршин суугчдад өөр амьдрах газар олгоно хэмээн амладаггүй атлаа шинэ байрны мөнгө шаарддаг байна.

Эдийн засаг, Нийгэм соёлын эрхийн тухай Олон Улсын Пактын хэрэгжилтийг хянадаг НҮБ-ын Эдийн Засаг, Нийгэм Соёлын Эрхийн Хорооны заасанчлан улс орнууд зөвхөн урьдчилан хамгаалах арга хэмжээ авсан үед л нүүлгэх ёстой билээ.

Эдгээр хамгаалах арга хэмжээ нь:

- Зөвшилцөх жинхэнэ боломжоор хангах, үүнд албадан нүүлгэхээс өөр тохирох арга замыг ярилцах
- Хангалттай анхааруулга, мэдэгдэл хүргүүлэх
- Нүүлгэхээс өмнө хангалттай хугацаа өгөх
- Нүүлгэхийн үед Засгийн газрын болон орон нутгийн захиргааны албаны хүмүүс байлцах
- Нүүлгэж буй хүмүүс өөрсдийн хэн болох, хаанаас явж байгаагаа тодорхой танилцуулах
- Хэрэв нүүлгэлтэнд өртөж буй хүмүүс зөвшөөрөөгүй бол аль болох шөнө үдэш, цаг агаар таагүй үед нүүлгэхээс татгалзах
- Тохиромжтой орон байрны сонголтоор хангах
- Хууль ёсны нөхөн төлбөр олгох
- Боломжтой бол хуулийн тусламж үзүүлэх

2009 оны 9 сарын 26-нд Бээжин хотод орон байрны эрхийн идэвхитнүүд Жин Еэхуа, Мао Хенгфенг, Шен Пейлан нар “ Шударга бус байдал”, “Төрийн гамшиг, ард түмэнд гамшиг болно”, “ Эрүү шүүлт, дарангуйллын эсрэг”, “Бидэнд ардчилал, эрх чөлөө, хүний эрх хэрэгтэй” (зүүнээс баруун тийш) гэсэн тэмдэг барин зогсож байгаа нь.

Хувийн хэвшлийнхний хүч хэрэглэн нүүлгэх, хүчирхийлэл, халдлагаас Засгийн газрууд ард иргэдээ хамгаалах ёстой. Хууль сахиулах хүчнийхэн зөвхөн шаардлагатай үед л хүч хэрэглэнэ.

Бүлэг дээрэмчид ирэх үед манайхан бүгд гэртээ байсан. Тэд манай гэрийн урд талаар 3 метр гүн нүх ухах эхэлсэн. Биднийг “зогсоогоочээ” гэж хэлэхэд огт сонсохгүй байсан болохоор цагдаа дуудсан. Тэгтэл цагдаа биднийг битгий саад бол гэсэн. Өнөө дээрэмчид үргэлжлүүлээд ажиллаад л байсан. Тэд зэвсэглэсэн байсан.

Хүбей мужийн У кань хотын иргэн Хуан Хунсиа.

Хадам ээж нь 2010 онд амьдаараа булуулж нас барсан юм.



ВАН ЦҮИ ЮНЬ

“Биднийг эргээд харахад л түүнийг булчихсан байсан”

2010 оны 3 дугаар сарын 20-нд Хүбей мужийн У кань хотод 70 гаруй настай Ван Цүи юнь 20 гаруй хөлсний ажилчин гэрийг нь нурааж байгааг зогсоох гэж оролджээ. Үл хөдлөх хөрөнгийн компаний хөлсөлсөн хүмүүс зэвсэглэсэн байв. Гэр бүлийхнийх нь хэлснээр нэг бол ажилчид хөгшнийг нүх рүү түлхсэн эсвэл өөрөө унаж, байшин нурааж байсан экскаватор шороогоор булсан. Түүний бэр Хуан Хунсиа “Биднийг эргээд харахад л ээжийг булчихсан байсан.” хэмээн ярьж байсан юм.

Ван Цүи юнь үл хөдлөх хөрөнгийн компанийхантай тохиролцоонд хүрчихсэн, юм хумаа боож баглаж байсныг нь барилгын ажилчид

хүлээлгүй гэрийг нь шууд нурааж эхэлсэн байна. “Хоёр цагдаа тэр дээрэмчдэд тусалсан. Ээжийг булсаны дараа л цагдаа зогсоон, түргэн тусламж дуудаж, эмнэлэгт хүргэсэн. Гэхдээ хүн 30 минут газарт булуулсаны дараа яаж амьд үлдэх билээ дээ” хэмээн Хуан Хунсиа үргэлжлүүлэн ярьсан юм.

Цагдаа барилгын даамал, экскаваторын жолоочийг баривчилсан орон нутгийн захиргаа хэргийг осол гэж зарлажээ. Мөн ямар ч нэмэлт мөрдлөг явагдаагүй тухай гэр бүлийнхэн нь хэлж байв.

ХАВЧЛАГА ДАРАМТ БА ХАЛДЛАГА

Эмнести Интернэшнлд ярилцлага өгсөн хүмүүсийн хэлснээр нүүлгэх ажиллагаа зарлагдмагц оршин суугчдыг гэр орноо хураалгаж, нөхөн төлбөр авах гэрээнд гарын үсэг зуруулах зохион байгуулалттай ятгах арга хэмжээг захиргааныхан болон үл хөдлөх хөрөнгийн компани явуулдаг байна. Улмаар ихэнх оршин суугчид аль болох хурдан гарын үсэг зураад, нүүж явдаг ажээ.

Хэрэв оршин суугчид татгалзвал асар их дарамталдаг байна. Захиргааныхан хүмүүсийг гэр орноо орхин гарах, улмаар гэрийг нь бульдозердохын тулд ус, дулаан, цахилгааныг хязгаарладаг. Эдгээр арга хэмжээ авахыг татгалзсан албан хаагчдыг ажлаас халах хүртэл шийтгэл оногдуулна.

Заримдаа эрх баригчид оршин суугчдыг нүүлгэхийн тулд цусан



Бээжин хот. 54 настай Гү Ванжу эцэг эхийнхээ зургийг барин зогсож буй нь. Түүний 70, 80 настай эцэг эх хоёр нь гэрийг нь албадан нураахаар ирсэн албаныханд зодуулж нас барсан байна.

төрлийн холбоог хүртэл ашигладаг байна. Жишээ нь 2011 оны 1 дүгээр сард Жиансу мужийн нэгэн хотын дунд сургуулийн захирал төрөл садангуудаа нүүлгэн шилжүүлэх гэрээнд гарын үсэг зурахыг ятгаж чадаагүй гэх шалтгаанаар хэд хэдэн багш нарыг ажлаас нь халжээ.

ЗОДУУЛСАН, ХУЛГАЙЛАГДСАН, АМЬДААРАА БУЛУУЛСАН ХЭРГҮҮД

Оршин суугчдыг гэр орноос нь албадан нүүлгэх оролдлого хүчирхийлэлд хүрсэн тоолж баршгүй олон тохиолдол байна. Бидний нарийвчлан шалгасан 40 хэрэгт гэхэд л 9 хүн нас барж, амьдаараа булагджээ. Нийт 6 эрэгтэй, 3 эмэгтэй нас барсан байна. Тэдний зөвхөн 2 хэргийг л аллага хэмээн үзжээ.

Дээрх үхлүүдээс гадна олон хүн нүүлгэх тухай гарын үсэг зурахаас татгалзсан, эсэргүүцсэнээсээ болж зодуулж, зарим нь баривчлагдан, хулгайлагддаг. Түүнчлэн хүчирхийллийг ихэнхдээ төрийн өмнөөс орон нутгийн цагдаа, "ченгуан" (хотын менежмент) болон бусад төрийн албан хаагчид үйлддэг байна. Зарим хэрэг дээр үл хөдлөх хөрөнгө зуучлалын хуйвалдаан төмөр, модон шидэм барьсан, хутга

өвөртөлсөн дээрэмчдийг хөлслөн оршин суугчдыг айлгаж, нээнтэглэдэг байна. Гэр орноо алдсан оршин суугч, хүний эрхийн идэвхтнүүд цагдаа нар дуудлага аваад ирдэггүй, хэт оройтож ирдэг, ирсэн нь юу ч хийлгүй зүгээр л хүчирхийллийг хараад зогсдог тухай Эмнести Интернэшнлд ярьсан юм.

Эдгээр гэмт хэрэг нь ихэвчлэн мөрдөн шалгагдалгүй өнгөрдөг бөгөөд зөвхөн олон нийтийн дургүйцлийг хүргэж, хүмүүсийн анхаарлыг татсан үед л хэрэгтнийг олж ялладаг байна.

2011 оны 7 дугаар сарын 11-нд Сичуан мужийн Венчан хотын цагдаа 20 сартай нялх хүүг эх Шу Хуагаас нь салган авч явж, нүүлгэн шилжүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурах хүртэл хүүг нь өгөөгүй байна. Цахилгааныг нь тасалсаны дараа орон нутгийн захиргааныхантай мөргөлдөж баривчлагдсан оршин суугчдын нэг нь Шу Хуа байсан юм.



2011 оны 5 дугаар 17-нд тариалангийн газрыг нь булаан авч байгаа тухай гомдол гаргахаар Пинчуан тосгоны иргэд захиргааны байранд ирэхэд Жианси мужийн Хесиа суурингийн албаныхан гэр бүл төлөвлөлтийн ажилтнуудыг дуудан ирүүлжээ. Гэр бүл төлөвлөлтийн ажилтнууд Зан Зулан гэх эмэгтэйг зодож, хүчээр үр боолгох мэс засалд оруулан үргүй болгосон бөгөөд энэ нь эрүү шүүлттэй дүйцэх хэмжээний харгислал мөн. Дараа нь албаныхан түүнийг нүүлгэн шилжүүлэх гэрээнд болон мэс засалд орохыг зөвшөөрсөн тухай баримтанд гарын үсэг зуруулахаар дарамталсан байна.

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу хүч хэрэглэхдээ зайлшгүй шаардлагатай байдал болон тодорхой заагаас хэтрэхгүй байх зарчмыг баримтлах ёстой билээ.

Ялангуяа нүүлгэн шилжүүлэлт нь оршин суугчдын нэр төр, аюулгүй байдал, амьд явах эрхийг зөрчсөн арга замаар явагдаж болохгүй.

Хүн бүр, онцгойлон хүүхэд, эмэгтэйчүүдийг шууд, шууд бус замаар халдлага, бусад төрлийн хүчирхийллээс хамгаалахыг олон улсын хуулиар шаардсан байдаг. Түүнчлэн улс орнууд нүүлгэн шилжүүлэх үед хүйсэд тулгуурласан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас эмэгтэйчүүдийг хамгаалах, хүүхдийн эрхийг хангах үүрэгтэй.

ШҮҮХДЭХЭД УЧРАХ БЭРХШЭЭЛ

Уул нь Хятадын хуулиар газар эзэмшигч, нөхөн төлбөр авах асуудлаа шүүхээр шийдвэрлүүлж болно. Мөн нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй хүмүүс шүүхдэхийн зэрэгцээ Засгийн газарт өргөдөл гаргах боломжтой. Зарим тохиолдолд хүмүүс жагсах, албаны хүмүүсийг дарамтлах зэрэг янз бүрийн арга хэрэглэх нь ч бий.

Гэвч хуульч, өмгөөлөгч, хохирогчдын хэлж буйгаар нүүлгэхийн эсрэг шүүхэд хандах, нүүлгэсний дараа шүүхэд хандлаа гэхэд үнэн мөнийг олох, шударга ёсыг тогтоох найдлага бараг үгүй.

Орон нутгийн намын хороо нүүлгэхтэй холбоотой хэргийг авч



үздэг шүүх, бусад албыг бүрэн хяналтандаа байлгаж, хүмүүсийн үр дүнтэйгээр хохирлоо барагдуулах боломжийг боогдуулдаг юм. Шүүх нүүлгэхтэй холбоотой өргөдөл гомдлыг ихэвчлэн хүлээж авдаггүй. Шүүхээс эерэг шийдвэр гарлаа ч гэсэн шүүх ямар нэгэн байдлаар нөхөн төлбөр олгох, хохирол барагдуулахад дурамжхан ханддаг байна.

Шаардлага хангахуйц хуулийн зөвлөгөө авч хохирлоо үр дүнтэйгээр барагдуулах оршин суугчдын эрх зөрчигдөж байна. Орон байрны эрхийн идэвхтнүүд, хуульчид ажлын гэрчилгээ, лицензээ алдан, халдлага, ядуурал, хүчирхийлэлд өртдөг тул зарим өмгөөлөгч албадан нүүлгэхтэй холбоотой хэрэгт ажиллахаас татгалздаг байна.

ТАЙВАН ЭСЭРГҮҮЦЛИЙГ ХҮЧЭЭР ДАРЖ БАЙНА

Хятадад албадан нүүлгэхийн эсрэг хийж буй жагсаал нь ихэвчлэн аль нэг тосгон, тухайн газраар хязгаарлагддаг. Эрх баригчид эсэргүүцлийн жагсаалыг маш түргэн нухчин дардаг бөгөөд энэ нь адилхан асуудалтай бусад газруудтайгаа холбоо тогтоож, үг хэлэх, нэгдэх эрхээ эдлэх боломжгүйд хүргэдэг.

Зарим тэмцэгч эв санааны нэгдэлтэй байхын тулд бусадтай холбогдох оролдлогуудыг хийдэг. Гэвч жагсаал цуглаан зохион байгуулах тэр ч байтугай мэдээлэл солилцох сүлжээ үүсгэх нь тун аюултай. Хятадад орон байрны эрхийн асуудлаар ажилладаг албан ёсны бүртгэлтэй Төрийн бус байгууллага (ТББ) байдаггүй.

Хохирогчидтой мэдээлэл солилцох, хуулийн зөвлөгөө өгөх үүднээс сайн дурын ажилтан илгээх хэрэгтэй болвол эрх баригчдын хараанд өртөхгүйг хичээх хэрэгтэй болдог тухай нэгэн идэвхитэн бидэнд ярьсан юм.

Хүчээр нүүлгэх ажиллагааг ил тод эсэргүүцсэн хүмүүс ихэвчлэн шоронд эсвэл засан хүмүүжүүлэх газар хоригдох ял сонсдог. Шандун мужийн эрх баригчид Ли Хун Вейнд 2011 оны эхээр олон нийтийн газар 2 удаа эсэргүүцлийн үг хэлсэнийх нь төлөө 21 сар хорих ял оноожээ.

Хамгийн түгээмэл тархсан зөрчил нь тариачдын газрыг дур зоргоороо хурааж байгаа явдал. Тэд маш их гомдолтой, тиймээс ч асар их эсэргүүцлийн ажиллагаа (жагсаал цуглаан) өрнөхөд хүргэж байна.

Ерөнхий сайд Вен Жиабао, 2012 оны 2 дугаар сард



ТАН ФУЗЕН

2009 оны 11 дүгээр сарын 13-нд дуулга өмсөж, төмөр шийдэм барьсан хүмүүс Тан Фузений гэрийнхэнийг хөөн гаргахаар иржээ. Олон улсын эрхзүйн хэм хэмжээг зөрчин эрх баригчид тэдний байшинг нураан уг газарт хурдны зам барих тухай мэдэгдлийг хүргүүлсэн байна. Тан Фузений гэр бүлийнхэн байраа нураалгахаас татгалзсан юм.

Тэр өглөө хүмүүс хүрч ирмэгцээ шууд зодож эхэлсэн байна. 47 настай Тан Фузен болон түүний хамаатнууд чулуу, бензин дүүргэсэн лонх шидэх зэргээр эсэргүүцэн тэмцсэн байна. Эцэст нь Тан Фузен дээвэр дээрээ гарч, өөр дээрээ бензин асган шатааж зулын гол болжээ. Тэрээр 16 өдрийн дараа нас барсан юм. Тан Фузений хэрэг албадан нүүлгэн шилжүүлэх ажиллагаанаас иргэдээ хамгаалж чадаагүй Хятадын Засгийн газрыг шүүмжлэх эхлэлийг тавьжээ. Одоо ч гэсэн нас барсан газарт нь хүмүүс очсон хэвээр.

ӨӨРИЙГӨӨ ЗОЛИОСЛОХ БУЮУ ЭЦСИЙН АРГА


Хууль ёсоор хохирлоо барагдуулж чадахгүй, тайван замаар эсэргүүцлээ илэрхийлэх эрхээ эдэлснийхээ төлөө баривчлагдаж, ямар ч хамаагүй үнээр хөгжлийг дагах гэсэн эрх баригчдад гадуурхагдсан иргэдийн зарим нь хэт туйлширсан эцсийн арга хэмжээ буюу өөрийгөө золиослож байна.

Хятад, англи эх сурвалжуудын мэдээлэлд тулгуурлан Эмнести Интернэшнл 2009 оноос 2011 оны төгсгөл хүртэлх хугацаанд хүчээр нүүлгэн шилжүүлэх ажиллагаатай холбоотой хэргийн улмаас амиа золиослосон 41 хэргийг баримтжуулсан билээ. Эдгээр 41 хүний 28 нь эрэгтэй, 10 нь эмэгтэй байв. Үлдсэн гурван хүний хүйсийг тогтоох боломж бидэнд олдоогүй бөгөөд тэдний найм нь амиа алдсан юм.

ДҮГНЭЛТ

Ерөнхий сайд Вен ЖиаБао тэргүүтэй Хятадын удирдагчид хүчээр нүүлгэн шилжүүлэх ажиллагаа асар их асуудалтайг хүлээн зөвшөөрсөн билээ. 2011 оны 1 дүгээр сард төв Засгийн газраас хотод нүүлгэн шилжүүлэлт хийхэд хүч хэрэглэхийг хориглож, нүүлгэгдэж буй байр эзэмшигчдэд шинэ хамгаалал олгосон бөгөөд олон нийтэд санал бодлоо илэрхийлэх, шүүхэд хандах, зах зээлийн үнэд суурилсан хангалттай нөхөн төлбөр олж авах эрхийг баталгаажуулсан байна.

Гэвч Хятадын Засгийн газрын бусад албаныхан нүүлгэн шилжүүлэх асуудлыг үл хэрэгсэн, хүчирхийллийг шинэчлэлийн явцад зайлшгүй гарах золиос хэмээн хаацайлдаг. Орон байрны эрхийн идэвхтнүүд, хуульчдын хэлж буйгаар хууль тогтоомж нь хангалтгүй бөгөөд уг хуулиар байр



эзэмшигчийн эрхийг хамгаалдаг болохоос түрээслэгчдийг огт хамгаалдаггүй ажээ. Түүнчлэн засгийн газар уг хамгаалалтыг хотын зах болон хөдөө орон нутагт амьдардаг хүмүүст олгоогүй юм.

Хөдөө, орон нутгийн иргэд хотынхоноос хамаагүй бага нөхөн төлбөр авдаг. Нэгдлийн эзэмшдэг газрыг зөвхөн газар тариалангийн зорилгоор ашиглах ёстой бөгөөд хэрэв газрыг төрийн мэдэлд авбал тухайн газрыг ашиглах зориулалтанд ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй. Үүний улмаас хотын захын хотжиж буй хэсэгт газрын үнэ тэнгэрт тулж байхад нөхөн төлбөр хэвэндээ байсаар л байна. Эргэн тойронд хотжилт асар хурдацтай явагдаж, өчүүхэн бага нөхөн төлбөр авсан тариачид бүхий л насаараа амьдарсан нутгаасаа холдож явахаас өөр аргагүйд хүрч байна.

Олон улсын хэм хэмжээний дагуу Засгийн газрууд бүхий л боломжит хувилбарыг авч үзэн хэлэлцсэний эцэст хамгийн сүүлчийн байдлаар нүүлгэн шилжүүлэх ёстой. Нүүлгэлт нь хүний зохистой орон байраар хангагдах эрхийг зөвхөн зөрчөөд зогсохгүй, ажиллах, эрүүл мэнд, боловсрол эзэмших, ус, ариун цэврийн үйлчилгээ авах эрхэнд нь ноцтой нөлөөлдөг болохыг тогтоосоны үндсэн дээр уг хэм хэмжээг боловсруулсан билээ. Хүмүүсийг хуулийн болон бусад хамгаалалтгүйгээр орон байр, газраас нь хөөн гаргах нь хүний эрхийн, тэр дундаа зохистой орон байраар хангагдах эрхийн ноцтой зөрчил юм. Эдийн засаг, нийгэм соёлын Эрхийн тухай Олон Улсын Пакт болон бусад олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдсэн гишүүн орны хувьд Хятад улс орон байраар хангагдах эрх, түүнд холбогдох баталгаажилтыг хүндэтгэх,

хамгаалах үүрэгтэй. Тиймээс ч албадан нүүлгэхийг хориглох ёстой.

Ван Ши Бо, 27 настай, 2 том самбар /Ерөнхийлөгч Ху Жин Тао, бусад эрх баригчдад хандсан амиа хорлох тухай бичиг/-ийн хажууд зогсож байгаа нь. Бээжин дэх гэрийг нь нүүлгэхээр хүмүүс ирэхэд Ван Ши Богийн гэр бүлийнхэн өөр дээрээ бензин асган, шатаж үхнэ хэмээн сүрдүүлсэн байна. Эсэргүүцлээ илэрхийлж тэрээр 2011 оны 3 дугаар сард амиа хорлох тухай бичиг, авсыг дэлгүүр дотор олны нүдэнд ил тавьжээ.

“Бид гэр орноо хамгаалахын тулд эцсээ хүртэл тэмцэх болно”

Ван Ши Бо, 2012 оны 3 дугаар сар



ЗӨВЛӨМЖ

- Бүхий л албадан нүүлгэх ажиллагааг зогсоож, хуулийн хүрээнд хориглох, олон улсын хуулийн дагуу зохистой хамгаалалтын механизмыг бүрдүүлэх, 2011 оны 1 дүгээр сард баталсан “Төрийн эзэмшлийн газарт байшин эзэмших болон нөхөн төлбөр олгох тухай” хуулийн хэрэгжилтийг хангах
- Албадан нүүлгэх ажиллагаа, бусад айлган сүрдүүлэг, халдлагаас хүн бүрийг хамгаалсан бодит, үр дүнтэй арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх
- Албадан нүүлгэлтийн улмаас ядуусыг орон гэргүй болгохыг таслан зогсоож, зохистой орон байртай болох боломжоор хангах
- Албадан нүүлгэх ажиллагааны хохирогчдод бие даасан, хараат бус шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх, хохирлоо барагдуулах нөхцлийг бүрдүүлэх
- Оршин суугчдын эрхийг зөрчсөн төрийн болон хувийн хэвшлийн ажилтнуудыг шүүж, тохирох ял шийтгэл оногдуулах
- Дээрх гол шинэтгэлийг хийж дуусах хүртэл томоохон албадан нүүлгэх ажиллагаа явуулахгүй байх

Дээд талын зураг: Хятадын Хэнан мужийн төв Зен Зоу хотод байшингаа нураалгахгүйн тулд бульдозерийн өмнө сууж байгаа эмэгтэй, 2007 оны 4 дүгээр сар
Урд талын нүүр: Өмнөд Хятадын Гуандон мужийн Яанжи тосгоныхон орон гэрээ нураалгахгүй гэж тэмцэж буй нь, 2012 оны 3 дугаар сар



Та бүхэн тайланг бүрэн эхээр нь www.amnesty.org/en/library/info/ASA17/001/2012/en хаягаар орж уншаарай.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь 150 гаруй улс орон, газар нутагт 3 сая хүнийг хамарсан хүний эрхийн хамгаалагчдын даян дэлхийн хөдөлгөөн юм.

“Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал” бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг энэ дэлхийн хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг, шашны үзлээс ангид - гишүүд болон олон нийтийн хандиваар санхүүждэг билээ.